

КОВИД-19 БА ЗҮҮН ХОЙД АЗИ, МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

М.Цолмон*, Б.Даваасүрэн**

Хураангуй: Аялал жуулчлалын салбар нь дэлхий дахины орчин үеийн хөгжлийн ерөнхий чиг хандлага болж буй байгаль орчинд ээлтэй, ногоон эдийн засгийн хөгжлийг дэмжсэн тогтвортой хөгжлийг дэмжсэн салбар юм.

Гэвч дэлхий нийтийг хамарсан цар тахлаас үүдэж уг салбарт таамаглахын аргагүй нөхцөл байдал үүсээд байна. Уг судалгааны ажлаар цар тахлаас үүдэж Зүүн Хойд Ази болон Монгол улсын аялал жуулчлалын салбарын орлогод үүсч болох эрсдэлийг таамаглахыг зорьлоо.

Түлхүүр үгс: аялал жуулчлалын салбар, олон улсын аялал жуулчлал, Монгол улс, Зүүн Хойд Ази, ковид-19, ДНБ

COVID-19 AND SITUATION OF TOURISM INDUSTRY IN NORTH EAST ASIA AND MONGOLIA

Abstract: Tourism sector is modern development drive that is environment friendly, supports green economy and sustainable development.

But, due to pandemic, this industry which had been expanding year by year faces unprecedented and unpredictable situation. This research aims to predict what kind of risks could affect tourism industry of North East Asia and Mongolia.

Key words: Tourism industry, international tourism, North East Asia, Mongolia, Covid-19, GDP

* МУИС-ийн Бизнесийн Сургууль, (E-mail) tsolmon.m@num.edu.mn

** МУИС-ийн Бизнесийн Сургууль, (E-mail) davaasurenb@num.edu.mn

Олон улсын аялал жуулчлалын хөгжлийн төлөв байдал

“Аялал жуулчлал”-ыг цогц байдлаар шууд тодорхойлоход бэрхшээлтэй, хүний бүхий л үйл ажиллагааг хамардаг, нийгмийн үзэгдэл, хүмүүсийн амьдралын салшгүй нэг хэсэг болсон ойлголт бөгөөд зөвхөн жуулчид болон аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчдэд үр өгөөжөө өгдөг бус, тухайн аялал явагдаж буй бүс нутгийн нийгэм соёл, эдийн засаг, улс төрийн хүрээнд нөлөөлж, их хэмжээний баялаг бий болгодог.

Дэлхийн 7 хүн тутмын нэг хэрэглэгч нь болж, тэдгээрт үйлчлэхээр 11 хүн тутмын нэг нь ажилладаг, нийт худалдаа эргэлтийн 7 хувийг дангаараа бий болгож, дотоодын нийт бүтээгдэхүүний 10.4 хувийг бүрдүүлж буй¹ аялал жуулчлалын салбар нь нэг талаас хүмүүсийн чөлөөт цагаа өнгөрөөж буй хэлбэр мэт харагдавч, нөгөө талаас энэхүү хэрэгцээг хангахад зориулагдсан үйлчилгээнүүдийг бий болгож байдаг, зах зээлийнхээ хүрээгээр дэлхийд тэргүүлэгч үйлдвэрлэлийн нэгд зүй ёсоор тооцогдож байна.

Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын “UNTWO World tourism barometer-2019” судалгаанаас үзвэл 1950 онд дэлхий даяар жуулчлах хүмүүсийн тоо жилд 25 сая байсан бол 2019 онд дээрх тоо 1,4 тэрбум болж нийтдээ 56 дахин, 2018 онтой харьцуулбал 3,8%-иар өссөн байна. Мөн 2019 онд дэлхийн эдийн засгийн өсөлт олон улсын худалдааны зөрчил гэх мэт асуудлаас шалтгаалан таамаглаж байснаас багаар буюу 3% өссөн байхад дэлхийн нийт ДНБ-д эзлэх аялал жуулчлалын салбарын өсөлт нь ерөнхий дунджаасаа дээгүүр буюу 3,8%-ийн өсөлттэй байсныг дурджээ. Уг тайланд дурдсанаар 2020 онд олон улсын аялал жуулчлалд эрсдэл учруулж болзошгүй улс төрийн тогтворгүй байдал, худалдааны зөрчил, Их Британи улс Европын Холбооноос гарсан үйл явдалтай холбогдон гарч болзошгүй эрсдэлүүд, мөн дэлхийн санхүүгийн тогтвортой байдалд учирч болох эрсдэлүүд гэх мэт хүчийн зүйлс байх таамгийг дэвшүүлж байжээ.²

Гэвч дэлхий нийтийн хэмжээнд Ковид-19 вирусээс үүдэлтэй цар тахал дэгдэж хэний ч санаанд оромгүй эрсдэл үүсч цаашид дэлхийн бүх хүмүүсийн амьдрал хэрхэн өрнөх, эдийн засагт ямар хүнд бэрхшээл үүсэх талаар таамаг дэвшүүлэхэд бэрх болоод байна. Уг цар тахлын эрсдэлд хамгийн эхэнд, хамгийн ихээр өртөж байгаа салбаруудын нэгээр яах аргагүй аялал жуулчлалын салбар нэрлэгдэж байна.

Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас 2020 оны 05 сард гаргасан “UNWTO World Tourism Barometer May 2020” тайланд дурдсанаар дэлхийн хэмжээний уг цар тахлаас үүдэн олон улсын аялал жуулчлалын салбарт дараах сөрөг үр дагаврууд үүсээд байна:

2020 оны эхний улирлын байдлаар олон улсын аялал жуулчлал өнгөрсөн оны мөн үетэй харьцуулвал 22%-иар, тоогоор илэрхийлвэл жуулчны тоо 67 саяар, мөнгөн

1 *Travel and Tourism – A Force for Good in the World, International Civil Aviation Organization, April 2018*

2 *World Tourism Barometer, World Tourism Organization, May 2020*


зарцуулалт 80 тэрбум ам.доллороор буурчээ. Хэрэв нөхцөл байдал яг өнөөдрийнх шиг цаашид үргэлжилбэл цар тахлын эсрэг улс орнуудын авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдээс хамаарч 2020 онд дэлхийн аялал жуулчлалын зах зээл 2019 онтой харьцуулахад 58-78%-иар агших төлөвтэй байна.

1. Аялал жуулчлалын зах зээлийн бууралтаас шалтгаалж салбартай шууд холбоотой 100-120 сая ажлын байр үгүй болох эрсдэлтэй.
2. Дэлхийн бүх улс орнууд улс дотроо үүссэн цар тахлын нөхцөл байдлаас хамаарч их, бага тодорхой хэмжээгээр хилийн хориг, улс дотроо хөл хорио тогтоогоод байна. Аялал жуулчлалын зорилгоор зорчин ирж буй хүмүүст нэгмөсөн болон хэсэгчилсэн хориг тогтоосон 97 улс, мөн 65 улс олон улсын нислэгийг хэсэгчилж болон бүрмөсөн, 39 улс бусад улс орнуудын нөхцөл байдлаас хамаарч тэдгээр улсуудад харилцан адилгүй хилийн хориг тавих гэх мэт арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.
3. Дэлхийн бүс нутгаар авч үзвэл аялал жуулчлал 2020 оны эхний улиралд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулвал Азийн орнуудад хамгийн өндөр буюу 35%, европт 19%, америк тивд 15%, африкт 12%, ойрх дорнодод 11% тус тус багасчээ.

Хэдийгээр “цар тахлын нөхцөл байдал харьцангуй дээрдлээ” гэж төсөөлж долоо, ес, арван хоёр дугаар саруудад олон улсын аялал жуулчлалын төлөв ямар байх талаар таамаглал дэвшүүлэх ажлууд хийгдэж буй ч нөхцөл байдал нэн тодорхойгүй байгаа учир урьдчилан хэлэхэд хүнд байна гэдгийг дурдсан бөгөөд ерөнхийдөө 2020 онд олон улсын жуулчдын тоо өмнөх онөөс 850 саяас 1,1 тэрбум орчим, салбарын орлого 910 тэрбумаас 1,2 их наяд ам.доллар, салбарын ажлын байрны тоо 100-120 сая орчим тоогоор тус тус буурна³ гэж таамаглажээ.

Дараах графикаас 2020 оны 1 улиралд олон улсын аялал жуулчлал дэлхийн хэмжээнд хэрхэн буурсныг харж болно.⁴

Зураг 1. Олон улсын аялал жуулчлал 2020 оны эхний улирлын байдлаар



Эх сурвалж: *International Tourism and Covid-19, UNWTO Global Tourism Dashboard, World Tourism Organization*

³ *World Tourism Barometer, World Tourism Organization, May 2020*

⁴ *International Tourism and Covid-19, UNWTO Global Tourism Dashboard, World Tourism Organization, May 2020*

Графикаас харвал 2020 оны эхний сарыг 2019 оны мөн үетэй харьцуулахад хэдий 2%-иар өссөн ч цар тахлаас шалтгаалан дараагийн саруудад огцом буурч, улирлын дүнгээр нийтдээ 22% уналттай байна.

Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын мэргэжилтнүүд олон улсын аялал жуулчлал хэзээ сэргэж эхлэх вэ гэх олон янзын таамгийг дэвшүүлж буйгаас олонх нь 2020 оны сүүлийн улирлаас эхлэн бага багаар сэргэж, 2021 оноос мэдэгдэхүүнд сэргэнэ гэсэн хүлээлттэй байна.⁵


Азийн аялал жуулчлалын нөхцөл байдал

2018 онд Ази тивийн хэмжээнд нийт 348 сая жуулчин айлчилсан нь өмнөх онтой харьцуулахад 7%-иар өссөн нь дэлхийн нийт жуулчдын 1/4-ийг эзэлж байв. Ази тивийг дотор нь бүслэн авч үзвэл Иранд жуулчлах жуулчдын тоо 50 гаруй %-иар, Энэтхэг, Непал, Шри Ланка зэрэг улсуудын жуулчдын тоо хоёр оронтой тоогоор өссөнөөс улбаалан өмнөд Азийн өсөлт 2018 онд тив дотроо хамгийн өндөр буюу 19% байжээ. Зүүн өмнөд Азийн тухайд гэвэл 7%-ийн өсөлттэй байсан ба уг өсөлтийг хамгийн ихээр тэтгэсэн улсуудыг дурдвал Вьетнам, Лаос, Камбож, Тайланд зэрэг улсууд байна.⁶

Манай Монгол улсын харъяалагддаг зүүн хойд Азийн өсөлтийг түүчээлсэн нь БНСУ, Япон, БНХАУ зэрэг улсууд байв.

2003 онд дэлгэрсэн SARS өвчин болон 2008 оны дэлхийн эдийн засгийн хямралаас үүдэлтэй 2009 оны бууралтыг эс тооцвол Ази тивийн хувьд аялал жуулчлалын салбар 1990 оноос хойш тасралтгүй өссөөр 2019 онд 361 сая жуулчин хүлээн авсан нь 2018 онтой харьцуулахад 4%-иар өссөн үзүүлэлт байв. Мөн дэлхий даяар жуулчилж буй нийт жуулчдаас Ази тивийг сонгон очдог жуулчдын тоо жил ирэх бүр өссөөр 2018 онд 25%-д хүрснийг дараах графикаас харж болно.

Зураг 2. Ази тивд жуулчилж буй дэлхийн нийт жуулчдын өсөлтийн төлөв байдал



Эх сурвалж: *Asia Tourism Trends – 2019, UNWTO/GTERC*

⁵ World Tourism Barometer, World Tourism Organization, May 2020

⁶ Asia Tourism Trends – 2019, UNWTO/GTERC, 2019

Гэвч хэний ч таамаглаагүй Ковид-19 вирусээс үүдэлтэй цар тахлын улмаас Азийн аялал жуулчлалын салбар дэлхийн бусад бүс нутагтай харьцуулахад хамгийн хүнд цохилтод ороод байна. 2020 оны 1-р улирлын дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулвал дэлхийн хэмжээнд аялал жуулчлалын салбар дундажаар 22% буурсан бол Ази тивийн хувьд нийтдээ 35%-ийн бууралтыг үзүүлжээ.

Хүснэгт 1. Ковид-19 вирусээс үүдэж дэлхийн бүс нутгууд дахь олон улсын аялал жуулчлал уналтад орсон байдал⁷

Бүс нутаг	Нэгдүгээр сар	Хоёрдугаар сар	Гуравдугаар сар	Дундаж хувь
Европ	6%	6%	-60%	-19%
Ази, Номхон далай	-2%	-37%	-64%	-35%
Америк	0%	3%	-46%	-15%
Африк	4%	4%	-44%	-12%
Ойрх Дорнод	6%	5%	-41%	-11%

Эх сурвалж: *International Tourism and Covid-19, UNWTO Global Tourism Dashboard, World Tourism Organization*

Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын мэргэжилтнүүдийн тооцоолсноор олон улсын аялал жуулчлал Ази тивийн түвшинд 2020 оны 6 сар гэхэд 3% хүртэл, 2020 оны 09 сар гэхэд 30% хүртэл, 2020 оны эцэс гэхэд 62% хүртэл, 2021 онд 100% хүртэл сэргэнэ гэсэн таамгийг дэвшүүлжээ.⁸

Зүүн Хойд Ази ба Монгол улсын аялал жуулчлалын төлөв байдал

2018 онд Ази тивд зочилсон олон улсын жуулчдын бараг тал нь буюу 49%-тай тэнцэх 169 сая жуулчид зүүн хойд Азийн орнуудад зорчсон гэж Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын баримтад дурдсан байна. Уг бүс нутгаас жуулчдыг хамгийн ихээр татсан нь БНХАУ, түүний засаг захиргааны тусгай нэгжүүд болох Хонг Конг болон Макао, мөн Япон, БНСУ зэрэг улсууд байна. Бүс нутгийн бусад улс орнуудын хувьд нийт жуулчдын тооны хувь харьцангуй бага ч жил тутмын өсөлт нь эерэг явж иржээ. Зүүн хойд Азийн нийт бүс нутгийн мөнгөн орлогын хувьд Ази тивийн нийт 435 тэрбум ам.долларын 43% нь ноогдсон байна.⁹

⁷ *International Tourism and Covid-19, UNWTO Global Tourism Dashboard, World Tourism Organization, May 2020*

⁸ *World Tourism Barometer, World Tourism Organization, May 2020*

⁹ *Asia Tourism Trends – 2019, UNWTO/GTERC, 2019*

Хүснэгт 2. Зүүн Хойд Азийн бүс нутагт зорчсон олон улсын жуулчид /бүс нутгаар/

						Бүс нутгийн эзлэх хувь	
Зүүн хойд Ази	2000	2010	2015	2017	2018	2010	2018
	58,366,000	111,508,000	142,075,000	159,515,000	169,190,000	1	1
Хаанаас:							
Ази, Номхон далай	49,233,000	94,867,000	124,617,000	139,679,000	148,097,000	85.1%	87.5%
Африк	154,000	571,000	634,000	652,000	681,000	0.5%	0.4%
Америк	4,077,000	6,426,000	7,195,000	8,281,000	8,832,000	5.8%	5.2%
Европ	4,517,000	8,961,000	8,970,000	10,274,000	10,886,000	8.0%	6.4%
Ойрх Дорнод	83,000	337,000	380,000	357,000	377,000	0.3%	0.2%
Бусад	301,000	346,000	279,000	272,000	317,000	0.3%	0.2%

Эх сурвалж: *Asia Tourism Trends – 2019, UNWTO/GTERC*

Дээрх хүснэгтээс харвал зүүн хойд Азийн бүс нутгийн жуулчид бүс дотроо түлхүү зорчдог нь харагдаж байна.

Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын тайлангаас харвал 2000-2018 оны хооронд олон улсын аялал жуулчлын хамгийн өндөр өсөлт Ази тивд ажиглагдсан бөгөөд үүний голлох шалтгаан нь БНХАУ-ын иргэд олон улсад жуулчлах хандлага жил ирэх бүр өсч буйтай холбоотой хэмээн дурджээ.¹⁰

Мөн Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын “Tourism 2020 Vision – Volume 7” тайланд дурдсанаар зүүн хойд Ази дахь аялал жуулчлалын өсөлт 1995-2019 оны хооронд жил тутам дунджаар 6,7%-ийн өсөлтөөр зүүн Азидаа тэргүүлсэн хэмээн тайлагнажээ. Уг тайланд дурдсанаар 2020 онд ч гэсэн уг бүс нутгийн аялал жуулчлалын салбарын өсөлт 6,7% байна хэмээн таамагласан байв.¹¹

Гэвч мөн л цар тахлын улмаас уг бүс нутгийн аялал жуулчлалын салбар үлэмж уналттай нүүр тулаад байна. Үүнийг Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын байгууллагын нийтэлсэн Зүүн Хойд Азийн бүс нутгийн хамгийн сүүлийн үеийн мэдээллээс харвал дараах байдалтай байна.

¹⁰ Asia Tourism Trends – 2019, UNWTO/GTERC, 2019

¹¹ Global Forecasts and Profiles of Market Segments, Tourism 2020 Vision, World Tourism Organization, Volume 7, 2020

Хүснэгт 3. Зүүн Хойд Азийн улс орнуудын аялал жуулчлалын уналтын байдал

Улсын нэр	Хугацаа	Уналтын хувь
Хонг Конг	2020.03 сар	-84%
Япон	2020.03 сар	-51%
БНСУ	2020.03 сар	-47%
Макао	2020.03 сар	-68%
Тайван	2020.02 сар	-36%

Эх сурвалж: *International Tourism and Covid-19, UNWTO Global Tourism Dashboard, World Tourism Organization*

Дэлхийн банкны статистик мэдээлэл /хавсралт 1/-ээс тооцож үзвэл зүүн хойд Азийн улс орнуудын ДНБ-д олон улсын жуулчдаас олох орлогын эзлэх хувь өнөөгийн зах зээлийн үнээр дараах байдалтай байна.

Хүснэгт 4: Зүүн Хойд Азийн улс орнуудын ДНБ-д аялал жуулчлалын салбарын орлогын эзлэх хувь

Улс		2000	2005	2010	2015	2019
Монгол	ДНБ-д жуулчдаас бүрдүүлэх орлогын эзлэх хувь	3.78%	8%	4%	2.37%	4.45%
БНХАУ		1.43%	1.28%	0.75%	0.4%	0.3%
Хонг Конг		4.77%	7.48%	11.9%	13.73%	12.23%
Макао		47.69%	59.38%	80.67%	69.44%	73.6%
Япон		0.12%	0.32%	0.27%	0.62%	0.94%
БНСУ		1.51%	0.92%	1.3%	1.35%	1.25%

Судлаачийн тооцоо

Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас гаргасан олон улсын аялал жуулчлалын салбарын 2020 оны бууралтын таамаг бодитой хэмээн тооцож уг үзүүлэлтийн дагуу статистик мэдээлэлд үндэлсэн регрессийн шинжилгээ хийж үзэхэд зүүн хойд Азийн орнуудын аялал жуулчлалын салбарын 2020 үзүүлэлт дараах үр дүнг үзүүлэх магадлалтай байна.

Хүснэгт 5. Зүүн Хойд Азийн орнуудын аялал жуулчлалын салбарын болзошгүй өөрчлөлт

Улс	2019 оны аялал жуулчлалын салбарын үзүүлэлт		2020 онд жуулчдын тоо 58%-иар буурах тохиолдол аялал жуулчлалын салбарт гарах өөрчлөлт			2020 онд жуулчдын тоо 78%-иар буурах тохиолдол аялал жуулчлалын салбарт гарах өөрчлөлт		
	Аялал жуулчлалын салбарын орлого	Хилээр нэвгэрсэн жуулчдын тоо	Жуулчдын тоо	Салбарын орлого	Өөрчлөлтийн хувь	Жуулчдын тоо	Салбарын орлого	Өөрчлөлтийн хувь
Монгол	607,000,000	577,300	242,466	123,484,926.65	79.7%	127,006	5,463,026.60	99.1%
Хятад	43,091,862,000	69,051,400	27,258,000	16,872,596,151.08	60.85%	14,278,000	4,400,474,372	89.78%
Хонг Конг	44,675,290,000	31,223,621	13,113,921	13,798,356,189.68	69.1%	6,869,197	2,024,784,103	95.46%
Макао	43,061,986,000	19,732,031	8,287,453	10,078,370,746.41	76.6%	4,341,047	0	100%
Япон	48,309,492,000	31,900,000	13,398,000	20,563,914,445.59	57.4%	7,018,000	12,110,261,471.04	74.93%
БНСУ	21,186,352,000	16,375,249	6,877,605	10,759,171,694.99	49.2%	3,602,555	6,690,830,951.17	68.41%
Дундаж	33,488,663,667			12,032,649,025.73	64.06%		4,205,302,820.635	87.44%

Судлаачийн тооцоо

Хүснэгт 6. Регрессийн томъёо

Улс	Регрессийн томъёо
Монгол	$Y = -124361063.5 + 1022.188637 * X$
Хятад	$Y = -9318859586 + 903.1041933 * X$
Хонг Конг	$Y = -10926145193 + 1885.363022 * X$
Макао	$Y = -16974425841 + 3264.307684 * X$
Япон	$Y = 2811243199 + 1325.023977 * X$
БНСУ	$Y = 2215656133 + 1242.222559 * X$

Судлаачийн тооцоо

Уг үр дүнгээс харахад Зүүн Хойд Азийн бүс нутгийн улс борон бүрт харилцан адилгүй үр дүн үзүүлэх нь харагдаж байна. Харин манай улсын хувьд аялал жуулчлалын салбар бүс нутгийн бусад улс орнуудтай харьцуулахад 2020 онд хамгийн өндөр эрсдэлтэй нүүр тулж магадгүй үр дүн гарч байна. Манай улсын аялал жуулчлалын салбарын мэргэжилтнүүдийн хэлж буйгаар цар тахлын улмаас аялал жуулчлалын салбартай холбоотой ажилладаг 120 гаруй мянган хүний ажлын байр шууд эрсдэлд орж байгаа ажээ.

Мөн 2020 оны эхний улирлын байдлаар:

- Экспорт 41,5%,
- Импорт 9,7%
- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 19,9%
- Уул уурхай, олборлох аж ахуйн үйлдвэрлэл 29,8%
- Жуулчдын тоо 51,6%
- Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 10,8%
- Улсын төсвийн алдагдал 19,3%
- Аялал жуулчлал 51,6%-иар тус тус буурч,
- Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 25,9%-иар өсчээ.¹²

Энэ бүхнээс харахад цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн уналт салбар бүрт нөлөөлж буй бөгөөд улмаар салбар хоорондын нөлөөлөл уг уналтыг улам бүр идэвхжүүлэх нь тодорхой.

Бусад улс орнуудын хувьд ч мөн адил дүр зураг харагдаж байгаа бөгөөд зүүн хойд Азийн улс орнуудын хувьд эдийн засаг болон аялал жуулчлалын салбараа тэтгэх, догодлоос сэргийлэхийн тулд төрөл бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал:

- Аж ахуйн нэгжүүдийн татвар төлөлтийн хугацааг хойшлуулах

¹² Корона вирус ба эдийн засаг, Үндэсний Статистикийн Хороо, 2020

- Зочид буудлуудын татвар төлөлтийн буцаан олголтыг өргөжүүлэх
- Татваргүй барааны дэлгүүрүүдийн патентыг төлбөрийг царцаах
- Ажил эрхлэлтийг дэмжихийн тулд салбарын аж ахуйн нэгжүүдэд татаас олгох
- Жижиг бизнесийн нэгжүүдийн үйл ажиллагааг хөнгөвчлөхийн тулд түрээслүүлэгчдийн татварыг хөнгөлж улмаар түрээсийн төлбөр төлөгч жижиг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих
- Зочид буудлын салбарын аж ахуйн нэгжүүдийн татварыг хөнгөлөх
- Аялал жуулчлалын салбар дахь бичил бизнес эрхлэгчдийг бэлэн мөнгөөр урамшуулах
- Аялал жуулчлалын үйл ажиллагааг эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд нэн хөнгөлөлттэй зээл олгох
- Дотоод аялал жуулчлалыг дэмжихийн тулд төрөл бүрийн хөнгөлөлтийн ваучер тараах
- Ажил эрхлэлттэй холбоотой даатгалын төлбөрийг хойшлуулах, цуцлах
- Ажилгүй иргэдэд бэлэн мөнгөний тусламж үзүүлэх гэх мэт арга, хэмжээнүүдийг дурдаж болно.¹³

Манай улсын хувьд төр засгий зүгээс эдийн засаг, нийгмийг тэтгэх олон арга хэмжээ авч буй хэдий ч аялал жуулчлалын салбарыг онилж шийдсэн тодорхой шийдвэр одоогоор гараагүй байна. Харин уг салбарын мэргэжилтнүүд, аж ахуйн нэгжүүд энэ онцгой цаг үед гадаад жуулчдын орон зайг дотоодын жуулчдаар хэрхэн нөхөж, дотоод аялал жуулчлалыг хэрхэн идэвхжүүлэх вэ гэдэг дээр хамтран ажиллацгааж байна. Манай улсын дотоод болон гадаад аялал жуулчлалын статистик мэдээллээс харвал гадаадын жуулчдын орон зайг хил энэ цаг үед дотоодын жуулчид бүрэн нөхөх боломжтой.

Улсын хилээр нэвтрэх жуулчдын орох болон гадаад жуулчлах иргэдийн гарах урсгалын тоон мэдээллийг дараах хүснэгтээс харж болно.

Хүснэгт 7. Монгол улсын аялал жуулчлалын орох болон гарах урсгалын мөнгөн дүн

	2014	2015	2016	2017	2018
Дотоодоос гадаад жуулчлагчдын зардал /ам.доллар/	529,000,000	473,000,000	536,000,000	618,000,000	822,000,000
Гадаад жуулчдаас олох орлого /ам.доллар/	215,000,000	246,000,000	316,000,000	396,000,000	461,000,000

Эх сурвалж: Дэлхийн банк

¹³ Covid-19: Measures to Support Travel and Tourism, World Travel Organization, May 2020

Хүснэгтээс харахад манай улын иргэд гадаадад зорчихдоо манай оронд зорчсон жуулчдаа олдог орлогоос илүү хэмжээтэй мөнгийг зарцуулдаг нь харагдаж байна. Улсын хил хаасан, гадаад орнуудын дахь цар тахлын аюул, эрсдэл өндөр, хөл хорио тогтоосон гэх мэт нөхцөл, байдлаас шалтгаалан гадаадад зорчигч Монгол иргэдийн тоо хэмжээ энэ онд эрс багасах нь тодорхой. Иймээс тэдгээр иргэдийг дотоодын аялал жуулчлалд татан оролцуулж, үйлчлэх бүрэн боломжтой.

Гэвч манай иргэд дотоодод жуулчлахдаа албан ёсны үйлчилгээ авахын оронд найз нөхөд, гэр бүлээрээ өөрсдийн дураар хувийн аялал хийх илүү сонирхолтой байдаг тул дотоодын жуулчдад зориулсан хөтөлбөр, аяллын багц зэргийг зохиох, олон нийтэд санал болгох, сурталчлах гэх мэт асуудал хүндрэлтэй байгаа нь ажиглагдаж байна.

Нөгөө талд дотоодын жуулчдын сахилга бат, эмх цэгц, дэг журмын гэх мэт асуудал нь аяллын үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгжүүдийн санааг зовоосон зүйл болоод байна. Иймээс дотоодын жуулчдын сахилга, хариуцлага ч мөн энэ цаг үед зайлшгүй анхаарах ёстой зүйл юм.

Дүгнэлт

Манай улсын аялал жуулчлалын салбар 2020 онд хүнд давааг давах нь тодорхой байна. Чухам хэр хүнд байх вэ гэдгийг хэн ч хэлж чадахгүй байна. Дэлхийн түвшинд ч уг салбарын төлөв байдлыг хэрхэх эсэхийг хэлэх хүн мөн алга.

Улс орон бүр энэ цаг үед цар тахлын эсрэг шат дараатай арга хэмжээг авч буй ч үр дүнд хүрэх цаг хугацаа нь давхцалын хувьд харилцан адилгүй байгаа тул ковид-19 вирус нэг хот, улсаас нөгөө хот, улсын хооронд шилжин тархах эрсдэл өндөр байна.

Мөн улс орнуудын засгийн газрын зүгээс цар тахлын эсрэг дорвитой үр дүнд хүрээгүй байхдаа эдийн засгийн уналтаас сэргийлж, хэт яаран хөл хориог цуцлах, зөөллөх арга хэмжээ авч байгаа нь тахлын вирус эргэн дэгдэхэд гол нөлөөг үзүүлж байна.

Энэ бүх үйл явдлаас дүгнэвэл манай улсын хувьд хилийн хоригоо хэзээ цуцлах вэ гэх цаг хугацааг тодорхойлох боломжгүй бөгөөд бизнесийн салбарын аж ахуйн нэгж, төлөөлүүд боломжит бүх арга замыг эрэлхийлж, улам бүр идэвхтэй, сонор сэрэмжтэй байхыг цаг үе шаардаж байна.

Судалгааны үр дүнгээс харахад хэрэв гадаад жуулчдын тоо өмнөх онтой харьцуулахад 78% багаслаа гэж тооцвол манай улсын аж ахуйн нэгжүүдийн хувьд гадаад жуулчдаас олох орлого бараг тэг хүрч унах эрсдэл байна. Хэдий тийм ч энэ цаг үеийг уналт гэж харах биш, дотоодоос гадагш чиглэх аялал жуулчлал мөн адил бүрэн шахуу хязгаарлагдаж байгаа тул уг боломжийг ашиглан дотоодын жуулчдаа илүү сайн таньж мэдэх, тэдэнд зориулсан зохих үйлчилгээг нэвтрүүлэх нь зүйтэй. Хэрэв ийнхүү амжилттай ажиллаж чадвал аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүд, хувь хүмүүсийн тодорхой хэсэг нь гадаад жуулчдаас бүрдүүлэх байсан орлогоо дотоодын аялал жуулчлалаас мөн тодорхой түвшинд нөхөж олох боломжтой байна.

Ашигласан материалын жагсаалт

- [1] Корона Вирус ба Эдийн Засаг, Үндэсний Статистикийн хороо, 2020
- [2] Travel and Tourism – A Force for Good in the World, International Civil Aviation Organization, April 2018
- [3] World Tourism Barometer, World Tourism Organization, May 2020
- [4] International Tourism and Covid-19, UNWTO Global Tourism Dashboard, World Tourism Organization, May 2020
- [5] Asia Tourism Trends – 2019, UNWTO/GTERC, 2019
- [6] Asia Tourism Trends – 2019, UNWTO/GTERC, 2019
- [7] Global Forecasts and Profiles of Market Segments, Tourism 2020 Vision, World Tourism Organization, Volume 7, 2020
- [8] Covid-19: Measures to Support Travel and Tourism, World Travel Organization, May 2020
- [9] World Bank Open Data, World Bank, 2020

Хавсралт 1: Зүүн Хойд Азийн улс орнуудын аялал жуулчлалтай холбоотой статистик мэдээ

№	Улсын нэр	Утга	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
1	Монгол	Аялал жуулчлалын салбарын орлого /минга/	43,000,000	49,000,000	143,000,000	154,000,000	205,000,000	203,000,000	261,000,000	349,000,000	272,000,000	253,000,000	288,000,000	197,000,000	215,000,000	236,000,000	257,000,000	279,000,000	379,000,000	462,000,000	526,000,000	607,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	154,207	187,434	228,719	201,153	300,538	338,768	404,480	451,788	446,393	411,664	456,090	460,360	475,892	417,815	392,844	386,204	404,163	469,309	529,370	577,300
		ДНБ /минга/	1,136,896,124	1,267,997,934	1,396,555,720	1,595,297,356	1,992,066,808	2,523,471,532	3,414,035,366	4,234,999,823	5,623,216,449	4,583,850,368	7,189,481,824	10,409,797,649	12,292,770,631	12,582,122,604	12,226,514,722	11,749,620,620	11,186,734,674	11,425,755,280	13,066,749,138	13,637,000,000
2	БНХАУ	Аялал жуулчлалын салбарын орлого /минга/	17,318,000,000	19,006,000,000	21,742,000,000	18,707,000,000	27,755,000,000	29,296,000,000	33,949,000,000	37,233,000,000	40,843,000,000	39,675,000,000	45,814,000,000	48,464,000,000	50,028,000,000	51,664,000,000	44,044,000,000	44,969,000,000	44,432,000,000	38,559,000,000	40,386,000,000	43,091,862,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	31,229,000	33,167,000	36,803,000	32,970,000	41,761,000	46,809,000	49,913,000	54,720,000	53,049,000	50,875,000	55,664,000	57,581,000	57,725,000	55,686,000	55,622,000	56,886,000	59,270,000	60,740,000	62,900,000	69,051,400
		ДНБ /минга/	1,211,346,869,605	1,339,395,718,865	1,470,550,015,082	1,660,287,965,663	1,955,347,004,963	2,285,965,892,361	2,752,131,773,355	3,550,342,425,238	4,594,306,848,763	5,101,702,432,883	6,087,164,527,421	7,551,500,425,598	8,532,230,724,142	9,370,405,738,740	10,438,529,153,238	11,015,542,352,469	11,137,945,669,351	12,143,491,448,186	13,608,151,864,638	14,200,000,000,000
3	Хонг Конг	Аялал жуулчлалын салбарын орлого /минга/	8,198,000,000	7,923,000,000	9,849,000,000	9,004,000,000	11,874,000,000	13,588,000,000	15,541,000,000	18,237,000,000	20,236,000,000	20,291,000,000	27,208,000,000	33,169,000,000	37,098,000,000	42,426,000,000	46,352,000,000	42,491,000,000	37,838,000,000	38,170,000,000	41,870,000,000	44,675,290,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	8,814,000	8,878,000	10,689,000	9,676,000	13,635,000	14,773,000	15,821,000	17,154,000	17,319,000	16,926,000	20,085,000	22,316,000	23,770,000	25,661,000	27,770,000	26,686,000	26,553,000	27,884,000	29,263,000	31,223,621
		ДНБ /минга/	171,668,164,083	169,403,241,524	166,349,228,737	161,384,522,525	169,099,768,875	181,570,082,162	193,536,265,094	211,597,403,594	219,279,678,430	214,046,415,026	228,637,697,575	248,513,617,677	262,629,441,493	275,696,879,835	291,459,356,985	309,383,627,029	320,860,698,504	341,687,111,841	362,682,018,243	365,100,000,000

4	Макао	Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	3,205,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	5,197,000
		ДНБ /минга/	6,720,492,406
5	Япон	Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	5,970,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	4,737,000
		ДНБ /минга/	4,887,519,660,745
6	БНСУ	Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	8,527,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	5,322,000
		ДНБ /минга/	561,633,125,840
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	7,917,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	5,147,000
		ДНБ /минга/	609,020,054,512
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	7,002,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	4,733,000
		ДНБ /минга/	680,520,724,062
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	8,222,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	5,818,000
		ДНБ /минга/	764,880,644,711
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	8,282,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	6,023,000
		ДНБ /минга/	898,137,194,716
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	8,437,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	6,155,000
		ДНБ /минга/	1,011,797,457,139
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	9,253,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	6,448,000
		ДНБ /минга/	1,122,679,154,632
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	13,440,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	6,891,000
		ДНБ /минга/	1,002,219,052,968
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	13,262,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	7,818,000
		ДНБ /минга/	901,934,933,365
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	14,315,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	8,798,000
		ДНБ /минга/	1,094,499,338,703
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	17,329,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	9,795,000
		ДНБ /минга/	1,202,463,682,634
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	18,731,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	11,140,000
		ДНБ /минга/	1,222,807,284,485
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	19,457,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	12,176,000
		ДНБ /минга/	1,305,604,981,272
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	22,390,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	14,202,000
		ДНБ /минга/	1,411,333,926,201
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	18,711,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	13,232,000
		ДНБ /минга/	1,382,764,027,114
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	20,924,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	17,242,000
		ДНБ /минга/	1,414,804,158,515
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	17,173,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	13,336,000
		ДНБ /минга/	1,530,730,923,149
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	33,456,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	28,691,000
		ДНБ /минга/	4,971,323,079,772
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	27,285,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	19,737,000
		ДНБ /минга/	4,389,473,622,589
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	20,790,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	13,413,000
		ДНБ /минга/	4,850,413,336,038
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	16,865,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	10,364,000
		ДНБ /минга/	5,155,717,036,271
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	16,197,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	8,358,000
		ДНБ /минга/	6,203,213,121,334
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	28,123,640,999
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	6,219,000
		ДНБ /минга/	6,157,459,594,824
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	21,475,520,709
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	6,790,000
		ДНБ /минга/	5,231,382,674,594
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	20,917,444,920
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	8,351,000
		ДНБ /минга/	5,037,908,465,114
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	18,340,447,243
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	8,347,000
		ДНБ /минга/	4,515,264,314,431
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	14,789,661,809
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	7,334,000
		ДНБ /минга/	4,530,377,224,970
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	10,683,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	10,610,000
		ДНБ /минга/	12,945,000
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	15,182,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	10,402,000
		ДНБ /минга/	11,926,000
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	43,031,377,366
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	13,577,000
		ДНБ /минга/	43,665,000,000
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	43,303,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	14,566,000
		ДНБ /минга/	31,500,000,000
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	31,015,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	15,703,600
		ДНБ /минга/	36,465,000,000
		Аяал жуулчдаанын салбарын орлого /минга/	40,358,000,000
		Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо	18,493,000
		ДНБ /минга/	43,061,986,000

Эх сурвалж: World Bank Open Data, World Bank